



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар A/79

Бор-Өндөр сум

Сангийн хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралт "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хоршоо хөгжүүлэх сан"-ийн төсөл сонгон шалгаруулах хорооны зөвлөлөөр хэлэлцэгдэн батлагдсан төсөл, санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад дурдсан төслийн хэрэгжүүлэгчдээс холбогдох материалыг бүрдүүлэн авч, зээлийн гэрээ байгуулж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн, "Хоршоо хөгжүүлэх сан"-ийн төсөл сонгон шалгаруулах хорооны нарийн бичгийн дарга (Ц.Мөнхгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Байгуулсан гэрээний дагуу "Хоршоо хөгжүүлэх сан"-аас 240,000,000 (хоёр зуун дөчин сая) төгрөгөөр санхүүжилт хийхийг Соёлын төв, сангууд хариуцсан нягтлан бодогч (М.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ

Сумын засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны
өдрийн 04 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

"Хоршоо хөгжүүлэх сан"-аас зээл олгогдох төсөл, санхүүжилт

№	Хоршооны нэр	Хоршооны регистр	Төслийн нэр	Чиглэл	Мөнгөн дүн	Утас
1	Зоост алаг	4212789	ЗООСТ	Мах сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй	80,000,000	99071332
2	Сод төгс жаргал урлан	4207785	Амжилт	Арьс ширэн эдлэл үйлдвэрлэх тоног төхөөрөмж, ажлын байртай болох	80,000,000	88740974
3	Баялаг батөндөр төгөл	4214323	Орон нутгийн хэрэгцээт өвлийн хүлэмжийн аж ахуй	Өвлийнхүлэмж барих	80,000,000	88605461
НИЙТ					240,000,000	